



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДЭРГЭДЭХ

**ЭМНЭЛЭГ ХӨДӨЛМӨРИЙН
МАГАДЛАХ ТӨВ КОМИСС**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 13/1, Утас: 32-80-30, Факс: (976-11) 32-07-16
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2015. 03. 30 № 49

танай _____ -ны № _____ -т

Тушаал хүргүүлэх тухай

Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссуудын нүүдлийн хурал зохион байгуулсан тухай 2012-2014 оны тайлангийн дүнд үндэслэн эмнэлэг хөдөлмөрийн магадлалын нүүдлийн хурлын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, магадлалын ажилд тавих хяналтыг сайжруулах зорилгоор “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын нүүдлийн хурал зохион байгуулах заавар”, “Нүүдлийн хурал зохион байгуулсан эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын тайлангийн маягтын загвар”, “Нүүдлийн хурал зохион байгуулах ажлын төлөвлөгөөний маягтын загвар”-ыг боловсруулж батлуулав.

Иймд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2015 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн “Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын нүүдлийн хурал зохион байгуулах заавар батлах тухай” А/36 дугаар тушаалыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллахыг мэдэгдэе.

2015 онд Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын нүүдлийн хурал зохион байгуулах ажлын төлөвлөгөөг дээрх тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан маягтын загвараар боловсруулан 2015 оны 4 дүгээр сарын 10-ны өдөрт багтаан Эмнэлэг хөдөлмөр магадлах төв комисст ирүүлнэ үү.

Хувийг Хөдөлмөрийн эрүүл мэнд судлалын төвийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисст

Хавсралт 6 хуудастай.

Хүндэтгэсэн,

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



П.МӨНХТУЛГА



**НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2015 оны 08 сарын 23 өдөр

Дугаар А/36

Улаанбаатар хот

**Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын
нүүдлийн хурал зохион байгуулах
заавар батлах тухай**


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6, Нийгмийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1, 29 дүгээр зүйлийн 3, Засгийн газрын 2015 оны “Дүрэм шинэчлэн батлах тухай” 11 дүгээр тогтоолоор батлагдсан “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”-ийн 6.1 заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын нүүдлийн хурал зохион байгуулах заавар”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Аймгийн эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын нүүдлийн хурал зохион байгуулах ажлын төлөвлөгөөний маягтын загвар”-ыг хоёрдугаар хавсралтаар, “Аймгийн эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын нүүдлийн хурал зохион байгуулсан тайлангийн маягтын загвар”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү заавар, маягтын загварыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисст даалгасугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс /П.Мөнхтулга/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.УРТНАСАН

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын
2015 оны 02 дугаар сарын 23 -ны өдрийн
А/36 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

**ЭМНЭЛЭГ ХӨДӨЛМӨРИЙН МАГАДЛАХ КОМИССЫН
НҮҮДЛИЙН ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗААВАР**

Нэг. Нийтлэг зүйл

- 1.1. Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс /цаашид “ЭХМК” гэх/ нь нутаг дэвсгэртээ Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын нүүдлийн хурал зохион байгуулахад энэхүү зааврыг мөрдөнө.
- 1.2. Алслагдсан сум, суурингийн иргэн (даатгуулагч)-д эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйлчилгээг ойртуулах, хугацаагүйгээр сунгагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийн болон хөдөлмөрийн чадвар алдалт, нөхөн сэргээлтийн байдалд хяналт тавьж, үнэлэлт өгөх зорилгоор ЭХМК-ын нүүдлийн хурлыг зохион байгуулна.
- 1.3. ЭХМК-ын нүүдлийн хурлыг сум дундын эмнэлэг болон нэгдүгээр зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төвийг түшиглэн зохион байгуулна. Шаардлагатай тохиолдолд ЭХМК-ын нүүдлийн хурлыг аймгийн төвөөс 200 км-аас дээш зайд алслагдсан, 3000-аас дээш хүн амтай суманд зохион байгуулж болно.
- 1.4. Мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын байдлыг шийдвэрлэх ЭХМК-ын нүүдлийн хурлыг тухайн иргэн (даатгуулагч)-ийн ажиллаж байсан үйлдвэр, уурхайн дэргэдэх сувилал, эмнэлгийн хэсгийг түшиглэн зохион байгуулж болно.
- 1.5. ЭХМК-ын нүүдлийн хурлаар иргэн (даатгуулагч)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг шинээр тогтоохгүй ба сунгах, цуцлах, хөдөлмөрийн нөхцөлийг өөрчлөх, ажлын цагийг богиносгох асуудлыг хянан шийдвэрлэнэ.
- 1.6. ЭХМК-ын нүүдлийн хурал зохион байгуулахад зарцуулагдах төсвийг тухайн Нийгмийн даатгалын хэлтэс нь жил бүрийн төсөвт төлөвлөж, батлагдсан төсөвт багтаан зохион байгуулна.

**Хоёр. Нүүдлийн хурал зохион байгуулах
бүрэлдэхүүн, үйл ажиллагаа**

- 2.1. ЭХМК-ын дарга нь нүүдлийн хурлын удирдамжийг баталж, хурал зохион байгуулагдахаас 30 хоногийн өмнө хурал зохион байгуулагдах сумын Засаг дарга, Эрүүл мэндийн төвийн удирдлагад хүргүүлсэн байна.


- 2.2. ЭХМК-ын нарийн бичгийн дарга, магадлагч эмч нар нь нүүдлийн хурал зохион байгуулагдах сумын эрүүл мэндийн төвтэй хамтран эмчийн үзлэг, магадлал хийх хуваарь гаргах, ил тод байрлуулах, хурлаар орох иргэдийг бүрэн хамруулах, үзлэг хийх, хурал зохион байгуулах байр болон шаардлагатай оношлогоо, шинжилгээний багаж, тоног төхөөрөмжөөр хангах, эмнэлэг хөдөлмөрийн магадлалын программ хангамжийг бэлдэх зэрэг бэлтгэл ажлыг хангасан байна.
- 2.3. ЭХМК-ын нүүдлийн хурлыг ЭХМК-ын дарга эсхүл орлогч дарга, магадлагч эмч, комиссын нарийн бичгийн дарга болон төрөлжсөн мэргэжлийн эмч нарын бүрэлдэхүүнтэйгээр, комиссын гишүүдийн 70 хувиас дээш ирцтэйгээр зохион байгуулах ба хурлыг ЭХМК-ын дарга эсхүл орлогч дарга удирдана.
- 2.4. ЭХМК-ын нүүдлийн хурал нь орон нутгийн суурин ЭХМК-ын хурлын нэгэн адил зохион байгуулалттай байна.
- 2.5. Сумын эмч нь иргэн (даатгуулагч)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтад нөлөөлж буй өвчин, эмгэгийн байдал, үйл ажиллагааны өөрчлөлт, алдагдал, холбогдох үзлэг, шинжилгээний өөрчлөлт, хяналтын хугацаанд хийгдсэн эмчилгээ, хөдөлмөрийн чадвар алдалтыг нөхөн сэргээх талаар авсан арга хэмжээ зэргийг тусгасан дүгнэлт бичиж, Эмнэлэг хяналтын комиссын болон ЭХМК-ын хуралд танилцуулна.
- 2.6. Иргэн (даатгуулагч)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг эрүүл мэндийн байгууллагын Эмнэлэг хяналтын комиссын дүгнэлтэд үндэслэн ЭХМК-ын олонхийн саналаар шийдвэрлэнэ.
- 2.7. Энэ зааврын 1.3-т заасан шаардлагатай тохиолдлоор ЭХМК-ын нүүдлийн хурал зохион байгуулахад иргэн (даатгуулагч)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг комиссын бүрэлдэхүүнд орсон төрөлжсөн мэргэжлийн эмчийн үзлэг, холбогдох шинжилгээний дүнд үндэслэн шийдвэрлэнэ.
- 2.8. ЭХМК-ын нүүдлийн хурлаар иргэн (даатгуулагч)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлэхдээ өмнөх шийдвэрийн дуусах хугацаанаас 30 хоногийн өмнө эсвэл хойно комиссын хурлаар хэлэлцүүлж болно.
- 2.9. ЭХМК-ын нүүдлийн хурал зохион байгуулах хугацаанд төрөлжсөн мэргэжлийн эмч нар нь сумын эмч нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хөдөлмөрийн чадвар алдалтаас сэргийлэх, бууруулах чиглэлээр сургалт зохион байгуулна.
- 2.10. ЭХМК-ын нүүдлийн хурлаар хэлэлцсэн иргэн (даатгуулагч)-ийн мэдээллийг эмнэлэг хөдөлмөрийн магадлалын программд бүртгэн, хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлэсэн хэвлэмэл актанд гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.

Гурав. Нүүдлийн хурлыг төлөвлөх, үр дүнг тайлагнах

- 3.1. ЭХМК нь нүүдлийн хурал зохион байгуулах төлөвлөгөөг тухайн оны 1 дүгээр сард багтаан Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссоор хянан батлуулж, мөрдөж ажиллана.
- 3.2. ЭХМК-ын нүүдлийн хурал зохион байгуулснаас хойш 14 хоногийн дотор Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисст илтгэх хуудсаар мэдээлнэ.
- 3.3. Тайлангийн жилийн эцэст тухайн жилд зохион байгуулсан ЭХМК-ын нүүдлийн хурлын нэгдсэн дүнг Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисст 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор тайлагнана.
- 3.4. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс нь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссоос ирүүлсэн тайланг нэгтгэн дүгнэж, дараа оны 2 дугаар сард багтаан Газрын даргын зөвлөлд танилцуулж, холбогдох арга хэмжээг авч ажиллана.

Дөрөв. Хүлээх хариуцлага

- 4.1. Эмнэлэг хяналтын болон ЭХМК-ын дарга, гишүүд нь үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомж, төрийн албан хаагчийн болон эмнэлгийн мэргэжилтний ёсзүйн хэм хэмжээг баримтлаж ажиллана.
- 4.2. ЭХМК-ын нүүдлийн хурлаар иргэн (даатгуулагч)-ийн хөдөлмөрийн чадвар алдалт, нөхөн сэргээлтийн байдлыг эрүүл мэндийн байгууллагын Эмнэлэг хяналтын комиссын дүгнэлтэд үндэслэхгүйгээр шийдвэрлэхийг хориглоно.
- 4.3. ЭХМК-ын нүүдлийн хурлыг зохион байгуулахдаа иргэн (даатгуулагч)-аас нэмэлт төлбөр хураамж авахыг хориглоно.
- 4.4. ЭХМК-ын нүүдлийн хурлыг зохион байгуулах үед алдаа зөрчил гаргасан, төрийн албан хаагчийн болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн, иргэн (даатгуулагч)-аас нэмэлт төлбөр хураамж, шан харамж авсан нь тогтоогдсон тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.



Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын
2015 оны 08 дугаар сарын 23 -ны өдрийн
АБГ тоот тушаалын хоёрдугаар хавсралт

..... АЙМГИЙН ЭМНЭЛЭГ ХӨДӨЛМӨРИЙН МАГАДЛАХ
КОМИССЫН НҮҮДЛИЙН ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ


.....он.....сар.....өдөр

Д/д	Хурал зохион байгуулах сумын нэр	Хамрагдах сумдын нэр	Хугацаа	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх үр дүн	Үйл ажиллагааны төсөв	Хамтран зохион байгуулах байгууллага
1							
2							
3							
4							

Төлөвлөгөө боловсруулсан:..... /..... /
гарын үсэг, тэмдэг нэр, албан тушаал

Төлөвлөгөөг хянасан:..... /..... /
гарын үсэг, тэмдэг нэр, албан тушаал

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын
 2015 оны 03 дугаар сарын 28 -ны өдрийн
 АЗГ тоот тушаалын гуравдугаар хавсралт



..... АЙМГИЙН ЭМНЭЛЭГ ХӨДӨЛМӨРИЙН МАГАДЛАХ
 КОМИССЫН НҮҮДЛИЙН ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛСАН ОНЫ ТАЙЛАН

Д/д	Үзүүлэлтүүд	1	2	3	4
1	Хурал зохион байгуулсан сумын нэр				
2	Хамрагдсан сумын нэр				
3	Хурал хийсэн огноо				
4	Хурлаар хэлэлцсэн хүний тоо				
	Үүнд:				
	ХЧА-ын хувийг хэвээр сунгасан				
	ХЧА-ын хувийг нэмэгдүүлсэн				
	ХЧА-ын хувийг бууруулсан				
	ХЧА-ын хувь цуцалсан				
	Хөдөлмөрийн нөхцөл сольсон				
	Ажлын цаг хорогдуулсан				
	Хурлаар шийдвэрлээгүй буцаасан				
5	Хуралд оролцсон гишүүдийн тоо				
6	Хуралдсан цаг				
7	Зарцуулсан зардал	Томилолтын зардал			
		Цагийн хөлс			
		Замын зардал			
8	Нүүдлийн хурлын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх талаарх санал				

Тайланг нэгтгэсэн:..... /..... /
 гарын үсэг, тэмдэг нэр, албан тушаал

Тайланг хянасан:..... /..... /
 гарын үсэг, тэмдэг нэр, албан тушаал

Тайланг нэгтгэсэн огноо:.....